



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар
хот


Улсын Их Хурлын тогтоолын
хэрэгжилтийг хангах тухай

Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцоо нийлж, дүнг Засгийн газрын санхүүгийн тайланд тусган шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайландаа тусгахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгасугай.

3. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг 1.0 (нэг) их наяд хүртэлх төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргаж нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН